с/авто зам, замын байгууламжийн зураг төсөл, хайгуул, барилга, их рын ажлын чанарт ноцтой зөрчил илэрснээс зөрчлийг арилгах хүртэл иг түр зогсоох, шаардлагатай гэж үзвэл ажлыг дахин шингэр илгүүдэх;

ж/улсын стандартын шаардлага хангаагүй зан барилгын материал, үүн үйлдвэрлэх, нийлүүлэх, ангилахыг хориглох, устгах, зөрчил нь илрэн гарах өөхнөл бүрдсэн тохиолдолд үйлдвэртэйг бүрмөсөн өх асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж, энэ тухай олон нийтэд н мэдэгдэх;

х/ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их ээний хохирол учирсан, гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсн мэдэлд шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий удиргад нисгэжүүлж шийдвэрлүүлэх.

Байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн, илэрсн ийг арилгуулах талаар тэмцсэн шаардлагыг биелүүлдэггүй гэм тай байгууллага, аж ахуйн нэгж, итгэхдгийг Захиргааны харууцлагын хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авто замын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу захиргааны шлага хүтээнгэж.

Дөрөв. Бусад зүйл

Авто замын улсын байцаагчийн шийдвэрийг байгууллага, аж ахуйн албан тушаалтан, иргэн хугацаанд нь биелүүлж, хэрнэг албан ёсоор илх үүрэгтэй.

Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд г шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн зан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шийдвэр хүлээн авсан с хойш 10 хоногийн дотор шалгалт хийсэн байгууллагын эрх инд буюу дээд шатны улсын байцаагчид гаргана. Гомдлыг хүлээн албан тушаалтан түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэртэй. Хэрэв энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд к болно.

Байцаагч нь энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй болон хууль мж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шлага хүлээнг.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 8 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1998 оны 12 дугаар зөвлөмж хэрэгжүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын дэд бүтэц сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цөмний энергийн комиссоос улсын хэмжээнд цацраг идэвхт үүсгүүрийн нэгдсэн тооллого явуулах, орчны цацрагийн түвшинг судалгаа хийх болон Изотоп конторын ажилчдыг тгээрлэх автомашин гараанаар хангахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улсын төм тусгуудан гаргах арга хэмжээ авахыг Сангийн сайдын үүрэг гүйцэт Б.Батбаярт даалгасугай.

2.Тус комиссыг ажлын нэгдсэн байр, цацрагийн хяналт, судалга ажилд шаардлагатай автомашингаар хангахыг Төрийн өмчийн хороо дарга З.Энхболдод даалгасугай.

3.Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 82 дү тогтоолоор баталсан хавсралтын "Хоёр. Дотоодын цэргийн гз хамгаалалтад байх объектууд" гэсэн хэсэгт "8.Изотоп контор" нэмсүгэй.

4.Байнгын ажиллагаатай Буюнт-ухаа, Замын-үүд, Сүхбаатар боо цацрагийн хяналтын суурин болон зөөврийн багаж төхөөрөмжөөр хл арга хэмжээ авахыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга З.Мөнхб даалгасугай.

5.Орчны цацрагийн түвшний хяналт-шинжилгээг ус, цаг уу ажиглалтын улсын сүлжээн дээр хийж дүнг цаг уурын харилцаа холбо сувгаар шуурхай мэдэлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль ор сайдын үүрэг гүйцэтгэгч С.Баярцогтод даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Сангийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

Б.БАТБАЯР

Гэгээрлийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

Байр худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 заалт, 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын ийн газраас **ТОГТООХ** нь:

Монголын залуучуудын холбооны гүйцэтгэх хорооны эзэмшилд эз төв байр, сургалт судалгааны төвийн байрыг Иргэний хуулийн 274-р зүйлд заасны дагуу Монголын залуучуудын холбоонд зохих журмын / үнхлж худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболлод өөрсүгэй.

Энэ тогтоол гарсантай холбогдуудан "Монголын залуучуудын судлагын өмчийн тухай" Засгийн газрын 1993 оны 1 дүгээр сарын 15-дрийн 4 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд угтай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
рэг гүйцэтгэгч

ЦЭЛБЭГДОРЖ

ангийн сайдын үүрэг
гцэтгэгч

Б.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 155

Улаанбаатар
хот

Бансны талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 хэсэг, 33 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын засгийн газраас **ТООХ** нь:

Төрийн өмчийн оролцоотой арилжааны банкууд дахь төрийн өмчийн эдийг хуудь тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн ны дарга З.Энхболлод үүрэг болгосугай.

2. Банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх явцад хяналт тавьж ажил төрийн өмчийн оролцоотой банкуудын эзллийн өрийг барагдуулах ажлуурхай зохион байгуулахыг Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгч С.Батчулуун, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Батбаяр, Төрийн өмч хорооны дарга З.Энхболд нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч	Ц.ЭЛБЭГДОРЖ
Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч	Б.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлогыг батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлого"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх талаар баримтлах бодол тусгагдсан зорилгуудыг тухайн жилийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Алтанхуяг, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Батбаяр нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч	Ц.ЭЛБЭГДОРЖ
Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч	Н.АЛТАНХУЯГ

АЖ ҮЙЛДВЭРИЙНГ СЭРТГЭХ, ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн амьдрал үйл байдлыг хангах зорилгоор ажиллагаа бүхий экспортны болон дотоодын бүтээгдэхүүний эрхэллийг нэмэгдүүлж, улмаар дотоод хөгжлийн нийцдэг хяналтаар улан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин дүтэх замаар уяж орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах төрөөс баримтлах бодлогын эрхэм зорилго юм.

Хоёр. Аж үйлдвэрийн хөгжүүлэх үндсэн чиглэл

Аж үйлдвэрийн хөгжүүлэх бодлогын зорилго нь дор дурдсан үндсэн зүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

а/экспортны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн гэрээтэй чиглэл болгон үлж, эдийн засгийн өөрчлөгөөс гэтлэх чадавхийг дэмжүүлэх;

б/үйлдвэрлэл эрхэлсний гаднад зөвхөн ажлынхны өртөгжүүлэн хөрөнгө оруулалт, технологийг дамжуулалтыг тууштай дэмжж, тэх ухаан, техникийн ололыг үйлдвэрлэлд эрчимтэй нэвтрүүлж, зах зин шаардлага хангасан уян технологийг бий болгох;

в/аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн, зах зин эдийн засгийг хөгжүүлэх суурь баялыг бэхжүүлэх;

г/биотехнологийн хөгжүүлж, эртэй болон хөдөө аж ахуйн ий эдийг иж бүрэн боловсруулж, зүй эмийн эрүүл мэнд, байгальд хор аюулгүй, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий м багтсамж сайтай, экологийн цэвэр, шинэ бүтээгдэхүүний эрхэллийг нэмэгдүүлэх;

д/орон нутагт импортыг орлох жижиг, дунд үйлдвэрлэлийг күүлж хэрэгцээг жигд хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх ир аж үйлдвэрийн хэт төвшөрлийг багасгах;

е/үйлдвэрлэлд үйлчлэх зөөлөн дэд бүтцийн тогтолцоог кронгуй болгон эрх зүй, бизнесийн талтай орчинг бүрдүүлэх.

Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого нь дараахь туудыг шийдвэрлэхэд чиглэнэ. Үүнд:

үдэс, түүхий эдийг боловсруулах салбар

а/байгаль оронцоо захиасан экологийн цэвэр бүтээгдэхүүний эрхэллийг нэмэгдүүлж, түүхий зах зин боловсруулалтыг гүнзгийрүүлэн баялгийн үйлдвэрлэлийн үр жонгог дэмжүүлэх;

б/үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн хүчин чадлыг ашиглалтыг сайжруулж дотоодын зарим үйлдвэрүүдийг түүхий эд хангах, нэвэр металл, хайлш гаргах, бага оврын техник, багаж хэрэгсэл үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлнэ;

в/газрын тосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар эцсийн бүтээгдэхүүн гаргах химийн үйлдвэрлэлийг байгуулж, шатаах, тос материал, зарим төрлийн органик бодис, уусгагчийн дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг

боловсруулах салбар

г/мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтыг түвшинг сайжруулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэмэгдүүлнэ;

д/түүхий эдийн ашиглагдаагүй байсан нөөцийг нэрүүлж судалж ашиглах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий шинэ нэр төр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлнэ.

е/хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, сав, баг, боодлыг боловсронгуй болгон, хүнсний аюулгүй байдал, эр ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэмэгдүүлнэ.

Бусад салбар

ж/байгалийн гаралтай түүхий эдийн ашиглалтын үр дүнг дэвшилтэт уураг, витаминг хүнсний бүтээгдэхүүн, эм, биобэлдмэл, үнэртэн гоо сайврууд, мал эмгэгч, хүнс тэжээлийн зарим бүтээгдэхүүний дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

З.Аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүд салбар бүрээр нарийвчлан боловсруулж хэрэгжүүлнэ.

Гурав. Аж үйлдвэрийг сэргээх бодлого

Аж үйлдвэрийг сэргээх бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэл баримтална. Үүнд:

4. Аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийн талаар

Аж үйлдвэрийн салбар дахь өмгө хувьчлалын үйл ажиллагааг эрчимжүүлэн, хувийн хэвшлийн үүрэг, үйлчилгээг нэмэгдүүлнэ.

5. Хөрөнгө оруулалтын талаар

а/гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, түүнийг үйлчлэх механизмыг боловсронгуй болгоно;

б/хөрөнгө оруулалтын арга, хэлбэрүүдийг шинэчлэн тэргүүтэй техник, технологийг аж үйлдвэрийн салбарт нэвтрүүлж, хөрөнгө оруулагчтай ажиллах хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

в/дотоодын хөрөнгө оруулагчдыг гадаадын хөрөнгө
улагчидтай адилтган үзэх хөнгөлөлтийн системийг бий болгоно.

Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх таатай
орчин бүрэлдэх талаар

а/мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эдийг
гэх, тээвэрлэх, хадгалах, боловсруулах тогтолцоог боловсронгуй
гоно;

б/ях эзэлийн зарчимд тулгуурласан бүс нутгийн өмчлөгч тохирсон
ий эд, бараа, бүтээгдэхүүний бөөний худалдааны сүлжээг хөгжүүлнэ;

в/улсын нөөц, төсвийн байгууллагын хэрэгцээг
өгдэхүүнийг үйлдвэрлэх үйлдвэрлэгчдийг тендерээр сонгон
гаруулж, дотоодын зах зээлийг ашиглах боломжоор хангана;

г/үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж
гэрэл бүрийн төлбөр, хураамж, зөвшөөрөл, үр дүнгүй олон
лт шалгалтыг цөөрүүлж, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх
цөөрлийн тогтолцоог халж бүртгэл хяналтын шинэ тогтолцоог
болгоно;

д/бүс нутгийг хөгжүүлэх хүрээнд гадаад, дотоодын
иэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд газрыг удаан хугацаагаар
ослуулэх асуудлыг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна;

е/хөдөө орон нутгийг бүсчилэн хөгжүүлж, алслагдсан бүс
рт аж үйлдвэрийн парк байгуулах талаар судалгаа хийж, энэхүү
ажиллагаанд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татан
цуулах боломжийг тодорхойлно;

ж/эх орны үйлдвэрийн болон экологийн цэвэр, уламж-
бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд сурталчилах, шинэ зах зээл
зуучлах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалахад гадаад
удал суугаа Элчин сайдын яам, Худалдааны төлөөлөгчийн
ын оролцоог идэвхжүүлнэ;

з/үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн мэдээлэл солилцоог
сүүлж, олон улсын мэдээллийн сүлжээнд холбох, түүнийг зөв
стой ашиглах үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Банк, санхүү, татварын бодлогын талаар

а/стратегийн ич холбогдол бүхий байгалийн болон мал, ан
ны гаралтай ховор түүхий эд, материалын экспортыг тарифын
варлалттай татварын бодлогоор зохицуулах асуудлыг
югдах байгууллагад гавьж шийдвэрлүүлнэ;

б/дотоодод үйлдвэрлэж байгаа зарим бүтээгдэхүүнтэй ижил
нийн импортын бүтээгдэхүүнд (гурил, тэмс, хүнсний ногоо,
йм төрлийн эм гэх мэт) гаалийн татвар ногдуулах замаар
юдын үйлдвэрлэгчдийн зах зээлийг хамгаалах бодлогыг

боловсруулан Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлнэ;

в) экпортын даатгал, урамшуулал, хөнгөлөлттэй зээл тогтоцооог бүрдүүлэх механизмийг бий болгож, зээл олгох, түүн буцаан төлүүлэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна;

г) аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх зорилгоор "Жижиг, үйлдвэрийг дэмжих" сангийн үйл ажиллагааг өргөтгөж, орон нутгийн импортыг орлох үйлдвэртэйг өсгөх зориулалтаар олгох зээлийн хэм хэмжээг дүүргэнэ;

д) хувийн хэвшлийн үйлдвэрүүдийг хөгжүүлэх, үйлдвэр, ахуйн байгууллагын техник, технологийг шинэчлэх, тэдний ажиллагаанд үндэслэл дүгнэлт өгөх, менежментийг боловсрон болгох чиглэлд Дэлхийн болон Азийн хөгжлийн банк, хандив орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, галаад о зээл, тусламжийг нарийвчилсан судалгаанд тулгуурлан олгоно.

8. Эрх зүйн шинэчлэлтийн талаар

Макро хэийн хэсгийн хүртэлд төрөөс хэргжүүлж буй суурь хэмжээгүүдэд тулгуурлан бизнесийн орчинг сайжруулахын тулд хосло хуудлийн төсөл боловсруулах, дагаж мөрдөж буй хуулиудад нэ өөрчлөлт оруулж, хэргжүүлэх арга хэмжээ авна.

Дорно, Шинэжлэх ухаан боловсролын талаар

9. Аж үйлдвэрийн салбарын боловсон хүчний мэхлэг чадв сайжруулж, давтан сургах, галаад, дотоодын их, дээд, тусгай мэргэж сургуулиуд болон менежмент сайтай үйлдвэрийн газруудад мэргэж боловсон хүчнийг шинээр бэлтгэх ажиллагааг өргөтгөж, удирдлага, зо байгуулалтыг боловсронгуй болгоно.

10. Улс орны хөгжлийн стратеги, бүтцийн бодлоготой уялдан шин ухаан техник, технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, улмэ технологийг боловсронгуй болгох, технологийг утгуудан хөгжүүдэх тэхийн хэийн хэсгийн шарьдлага хангасан үйл технологийг болгоно. Үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний төрлийг охируулахад, эрдэмтэд, судлаачдын үйл ажиллагааг чиглүүд үйлдвэрийг шинэжлэх ухаан-техникин хөгжилд тулгуурлан хөгжүүлнэ.

11. Аж үйлдвэрийг хөгжүүдэх талаар судалгааг шинэчилгээний а явуулах, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай төсөл боловсру шинэ технологи судлахад шинэжлэх ухааны байгууллагын үйл ажилл өргөжүүлэн, үр дүнг үйлдвэртэд нэвтрүүлэх замаар шинэжлэх ү: үйлдвэрлэлийн хослоог бэхжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

᠑98 оны 8 дугаар
арын 21-ний өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Экспортын үйлдвэрлэлийг дэм-
жих хөтөлбөрийг батлах тухай

асгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
лгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийг хавсралтын
р баталсугай.

"Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх
г удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг
й Үндэсний зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

г.

Зөвлөлийн дарга	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд
Гишүүд:	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Дэд бүтцийн хөгжлийн яамны Тө- рийн нарийн бичгийн дарга;
	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Байгаль орчны яамны Төрийн на- рийн бичгийн дарга;
	-Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Гадаад харилцааны яамны Төрийн

нарийн бичгийн дарга;

-Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга.

Нарийн бичгийн дарга

-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын дарга

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч

Н.АЛТАНХУЯЙ

Засгийн газрын 1998 оны дугаар тогтоолын хам

ЭКСПОРТЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын экспортын өнөөгийн байдал

Манай Улсын экспортын бараанд хөдөө аж ахуй, уул ууц үйлдвэрлэлийн түүхий эд, тэдгээрийн хагас боловсруулсан бүтээгдэхүүн хиллэж байна. 1997 онд экспортын нийт барааны 55,9 хувийг эрдэс тэжээл, 22,5 хувийг нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, бусад хувийг төмөр, түүхийн бүтээгдэхүүн, хаягдал төмөр, түүхийн болон боловсруулсан шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл, амьт мал, амьтан, урга гаралтай бүтээгдэхүүн, мод, модон эдлэл эзэлж байна. 1997 оны экспорт гаргасан бараа бүтээгдэхүүний 57,2 хувийг түүхий эд эзэлжээ.

Сүүлийн жилүүдэд ноолуур боловсруулах чиглэлээр гадаадын хөрөнгийн олон үйлдвэрүүд ашиглалтад орж энэ чиглэлээр 19 том, 4 компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай орны экспортыг нэмэгдүүлдэг АНУ болон Европын холбоо үзүүлж буй худалдааны хөнгөлөлт чухал үүрэг гүйцэтгэж, 1997 он орчим сая ширхэг оёмол бүтээгдэхүүн эдгээр орнуудын зах зоргоор экспортлогдсон байна.

1997 онд малын тоо толгой 31,3 сая болж ноос, ноолуур болон төрлийн ялангуяа, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлдэг үүсвэрийг бий болгож байгаа юм.

Аялал, жуулчлалын үйл ажиллагаанд 260 гаруй албан байгууллага, ажлын нэгжүүд оролцож, манай улсын экспортын чадавхийг нэмэгдүүлэхэд ихой хувь нэмэр оруулж байна.

1. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулах эсгэл

/Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсын хөгжлийн үндэсний зорилго"-ын 3.3 дахь хэсэгт экспортын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх зорилгыг дэвшүүлэн тавьсан.

Эсгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эзлэх боловсруулалт хийж, экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг өсгүүлэх зорилгоор үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг анх болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

1. ЗОРИЛГО

Хөтөлбөрийн зорилго нь экспортын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, ар дотоодын мөнгөн хуримтлалыг бий болгон, валютын нөөцийг гүйцэтгэх замаар улс орны эдийн засгийн чадавхийг сайжруулж, эдийн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

2. ЗОРИЛТ

а/уул уурхайн үйлдвэрлэлийн экспортыг өргөжүүлэх;
б/эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эзлэх гүйцэтгэх боловсруулалт хийж, улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий экологийн цэвэр, эсийн гадаргууны экспортыг нэмэгдүүлэх;

в/зах зээлийн шинэ сувгуудыг нээх, гадаад худалдааг өргөтгөн экспортын гарцыг олшруулах;

г/орон нутагт экспортын үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт үүсгэх;

д/аялал, жуулчлалыг хөгжүүлэн экспортын хүрээг өргөжүүлэх;

е/экспортыг дэмжих, урамшуулах эрх зүйн орчин, зөвлөн дэд зорилгыг боловсронгуй болгох;

ж/тодорхой хот, бүс нутагт олон улсын худалдааны төвүүдийг үүсгэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дахь чиглэлийн үйл ажиллагаа болон аж ахуйн нэгж, ууллагуудыг тэргүүн ээлжинд дэмжинэ. Үүнд:

а/уул уурхай, эрдэс түүхий эл, металлургийн боловсруулалтын эвдрэл;

б/газрын тос, нефтийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл;

в/хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах ба экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэр;

г/экспортыг өргөжүүлэх аялал жуулчлал;

д/экспортын үйлдвэрлэл хөгжүүлэх боломж бүхий бүс, орон нутгуд бүтцийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд;

е/техник технологийг боловсронгуй болгох, шинэчлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай судалгаа, төсөл;

ж/үндэсний гар урлал, урлаг уран сайхны бүтээл.

6.Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүнд дурдсан салбаруудыг онцлон анхаарч дараахь чиглэлийн ажислагааг зохион байгуулна. Үүнд:

Газрын тос, эрхл баялагийн салбар

а/одоо ажиллаж байгаа олборлох үйлдвэрүүдийн эрхл чадлын ашиглалтыг дээшлүүлэх, түүхий эдийн боловсруулах түвшинг сайжруулж, улмаар цэвэр металл, эцсийн бүтээгдэхүүн экспортыг нэмэгдүүлэх;

б/газрын тосны эрхл хайгуулын ажлыг түргэтгэж, найдвар нөөцөд тулгуурлан боловсруулах үйлдвэр байгуулах;

в/"Эрдэнэт" үйлдвэрт технологийн шинэчлэлт хийх, их хэмжээ бүтэн нөөц бүхий адуу агуулгатай хүдрийг боловсруулж цэвэр металл гаргах;

г/элт олборлолт, боловсруулалтын технологийг боловсруулж, байгальд нөлөөлөх нөлөөллийг багасгах;

д/ховор ба ховорлог металлмыг тэргүүний дэвшилтэт технологи боловсруулах арга хэмжээ авах;

е/Төмөртэй, Баянголын төмрийн хүдэр, Дорнод бүсэд орд Төмөргийн овоо, Улааны цайр, хар тугалга голдосон хол металлмыг ашиглах.

Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар

а/мал аж ахуйн гаралтай уламжлалт бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;

б/үндэсний технологийг бий болгож, түүнд түшиг үйлдвэрлэл явуулах "Техно-парк" байгуулах асуудлыг судлах;

в/экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүдийг бүс нутагт түлхүү хөгжүүлэх;

г/маж боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологийг улсын стандартын түвшинд шинэчлэх;

д/махыг бэлтгэх, савлаж боох, хадгалах ажиллагааг боловсруулж олон улсын стандартад тэнцүүлэх, түүнчлэн адуу, үхрийг эрч бэрлэх аргаар аялагдсан мах гаргаж экспортлох;

с/газар тариалангийн илүүдэл бүтээгдэхүүний экспортыг нэгдүүлэх.

Аялал жуулчлалыг дэмжих талаар

а/аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаад сурталчилгааг гөжүүлэх;

б/аялал жуулчлалын ач холбогдол бүхий нутаг дэвсгэрийг бүсчлэн гжүүлэх;

в/ан амьтан, загас агнуур, усан спорт, морь, тэмээ, явган аялал зэрэг ниллаар аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх;

г/аяллын шинэ чиглэл, үзвэр үйлчилгээ бий болгож, томоохон зочид уудлуудын тохижилт, менежмент, үйлчилгээний чанарыг сайжруулах.

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа

7.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нилуулах, хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл гүйцэтгэнэ.

8.Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхтэй байна.Үүнд:

-Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

-Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

-Хөтөлбөрт өөрчлөлт, тодотгол хийх саналыг Засгийн газарт тавьж илгэрлүүлэх;

-Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй илгэрлөх асуудлыг Засгийн газар болон холбогдох яам, газруудад тавьж илгэрлүүлэх.

9.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан юм. Зөвлөл нь удирддаг нэгтгэж доошгүй удаа хуралдах бөгөөд ардлагатай үед зөвлөлийн дарга хурлыг зарлан хуралдуулж болно. зөвлөлийн үйл ажиллагааг тус зөвлөлөөс баталсан дүрмээр зохицуулна.

10.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дараахь эх үүсвэрүүдийг илгэрнэ. Үүнд:

1.Улсын төсөв

2.Гадаадын хөрөнгө оруулалт

3.Дэлхийн болон Азийн хөгжлийн банк, хандивлагч орон, олон улсын иргүүллагын зээл, тусламж

4.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

11.Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг 1998-2010 оны ацаанд хэрэгжүүлнэ.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр гарах үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараахь үр дүнд хүрнэ.Үүнд:

12.Дотоодын мөнгөн хуримтлал, валютын нөөц нэмэгдэж, улс орны

эдийн засгийн чадавхи сайжран, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хур түргэжжээ чаашдын тогтвортой хөгжлийн суурь бэлжинэ.

13.Оршин үеийн тэргүүний, дэвшилтэт шинэ технологийг нутагшууц технологийг дамжуулалтыг эрчимжүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, чанартай, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

14.Монгол улсын олон улсын хөдөлмөрийн харилцаанд ороо оролцоо өргөжин тэлж, талаад хамтын ажиллагаа хөгжиж, дэлх хөгжлийн зүй тогтолтой уялдан үйлдвэрлэлийн сүлжээ бий бс маркетинг, менежментийн шалгарсан аргуудыг өөрийн орны нөхцө зохицуулан нэвтрүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг боловсрон болгох боломж нээгдэнэ.

15.Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэн, ажлын байр шинээр болж, хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ хангагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 8 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар
хот

Нэгдэл байгуулах тух

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйл 1 дэх хэсгийн 3, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заас үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Уламжлалт анагаах ухааны төв"-ийн одоогийн орон тоо, төв багцан Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл нэгдэл (корпораци)-ийг байгуулан ажиллуулсугай.

2."Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоол баталсан "Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц, өөрчлөлт хийх чиглэл" гэсэн 1 дүгээр хавсралтын 19-д "Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үндэсний төв" гэж заасныг хассугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

ЦЭЛБЭГДОРЖ

Гэгээрлийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1998 оны 8 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар
хот

**Тогтоол хүчингүй болсонд
төсөөх тухай**

"Индустри хуулийн нэдийн 1998 оны 4 тоот дүгнэлтийн тухай" Улсын Их
хурлын 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 76 дугаар тогтоолыг
эзэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь.
"Зүүрчлийн уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох тухай"
ийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар
хэргийг хүчингүй болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
эрх гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Хууль зүйн сайдын үүрэг
гүйцэтгэгч

С.БАТЧУЛУУН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1998 оны 8 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

"Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх
айм 4-г заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь.
Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдсэн Корпораци-ийн
чилсэн дүрмийг хавсралтын ёсоор батлосугай.
Энэ тогтоол гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологи,
эрэлхийн нэгдсэн Корпораци-ийн дүрмийг батлуулан мөрдүүлэх арга
гэрээг анхны Гэзэгийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ч.Сайханбилэгт
асугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
эрх гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Хууль зүйн сайдын үүрэг
гүйцэтгэгч

Ч.САЙХАНБИЛЭГ

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
НЭГДЭЛ /КОРПОРАЦИ-ИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ****Нэг. Найтлаг үндэстэл**

1. Энэхүү үлгэрчилсэн дүрмээр Шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэлийн нэгдэл /цаашид "нэгдэл" гэх/-ийг байгуулах болон түүн эрх, үүрэг, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцаа зохицуулана.

2. Нэгдэл нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааг хослон явуулах эрдэм шинжилгээний байгууллага мөн.

3. Нэгдлийг шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13 дугаар зүйл заасны дагуу байгуулна.

4. Нэгдэл нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай болон Технологи дамжуулах тухай хууль, Төрийн бусад орон нутгийн өмчийн тухай хууль болон хууль тогтоомжийн бусад зүйлс удирдлага болгоно.

5. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой нэгдэл нь энэхүү үлгэрчилсэн дүрмийг үндэслэн өөрийн үйл ажиллагааныхаа онц тохирсон дүрмийг боловсруулж удирдах /төлөөлөн удирдах/ зөвлөлөө батлуулан мөрдөнө.

6. Нэгдэл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичиг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Нэгдлийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоосон журмын дагуу улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.

8. Нэгдлийн бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл, бизнес эрхлэдэг нэгж нь улсын татварын албанд бүртгүүлдэг.

Хоёр. Нэгдлийн эрх, үүрэг

9. Нэгдэл нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх болон үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд дараахь эрх эдгээр а/эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлынхаа үр ашиглах, технологи дамжуулах үйл ажиллагаа явуулах;

б/дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай шинжлэх ухаан, технологийн болон үйлдвэрлэл, бизнесийн хүрээнд хамтран ажил хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, зуучлах;

в/эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр ашгийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд нэгдэх, сурталчлах, худалдаа борлуулах;

г/туршигтгын бүтээгдэхүүнээ борлуулсны орлогыг шинжлэх ухаан, югийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дэхь хэсэгт заасан талгаар зарцуулах;

д/өөрийн эд хөрөнгийг үйл ажиллагааныхаа жорилгод нийцүүлэн талтын дагуу эзэмшж ашиглах, үндсэн хөрөнгөд хамаарах эд гө олж авах;

е/дотоод, гадаадын болон олон улсын шинжлэх ухааны байгууллага, элж, холбоонд гишүүнээр элсэх, тэдгээрийн үйл ажиллагаанд ох, удирдлагад сонгогдох;

ж/хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

Нэгдэл нь дор дурасан үүрэгтэй байна:

а/холбогдох салбарын шинжлэх ухаан, технологийн бодлогыг ойлгоход оролцох, туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

б/эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлыг шинжлэх ухааны түвшинд гүйцэтгэх;

в/эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг туршичирлэх арга хэмжээ авах;

г/ эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх тухай аячтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй эсхүл үй буюу дутуу биелүүлсэн тохиолдолд чанарын зохио түвшинд, хохирлыг арилгах ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх буюу олгосон нийг нөхөн төлөх;

д/туршигтгын бус үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааг татварын сууль тогтоомжид нийцүүлэн явуулах;

е/төрийн өмчийн нэгдэл нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн ая хангаж, тэдгээрийг данснаас хасах, шинжүүлэх, актлах саналаа н өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэх.

Гурав. Нэгдлийн бүтэн, удирдлага

Нэгдэл нь бүрэлдэхүүндээ төв, салбар, лаборатори, туршилт, ын цех болон үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах нэгжтэй болно.

Төрийн өмчийн нэгдэл нь удирдах зөвлөл, эрдмийн зөвлөлтэй байж бөгөөд тэдгээрийг байгуулахдаа дараахь зарчмыг удирдлага ө. Үүнд:

а/удирдах зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны гууллага, холбогдох чиглэлийн яамнаас тус бүр 2, Шинжлэх ухааны нас 1 төлөөлөлтэй байх;

б/зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх;

в/удирдах зөвлөлийн даргыг шинжлэх ухаан, технологийн асуудал н төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор ийн хурлаар гишүүдийн олонхийн саналаар томилгох;

г/Удирдах зөвлөлийн ажиглах үндсэн хэлбэр нь хуралдаан (бөгөөд гишүүдийн дайтгах олонхи нь оролцсон тохиолдолд хуралдаан хүчинтэйд тооцно. Удирдах зөвлөлийн хуралдааныг улсралд идэвхгүй удаа хуралдуулах;

д/дармаах асуудлыг удирдах зөвлөлийн хуралдаанаар хэтэр олонхийн саналаар нийцвэр гаргана. Үүнд:

- нэгдлийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж, шинэжлэх ух
- технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал болго
- нэгдлийн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- нэгдлийн бизнес төлөвлөгөө, жилийн төслийг батлах;
- нэгдлийн зохион байгуулалтын бүтэц, налингийн сан, урамж
- журмыг тогтоох;
- нэгдлийн бизнес төлөвлөгөөний болон төслийн гүйцэтгэлийн т
- гүйцэтгэх захирлын тайланг хягалгах;
- бусад асуудал.

е/эрдмийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд зөвлөл нь нэгдлийн судалгаа шинжилгээний ажлын чиглэлийг тодорхой түүний жил, үр дүн болон эрдэм шинжилгээний бүтээлийн чанар, түвшин, дүгнэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй байх;

ж/эрдмийн зөвлөлийг нэгдлийн гүйцэтгэх захирал даргалэх бөгөөд түүний бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын саналыг үндэстэн Шинэ ухааны академи батлах;

з/нэгдлийн эрдмийн зөвлөлийн ажиглах хэлбэр нь хуралдаан бэ. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь оролцсон тохиол хурмыг хүчинтэйд тооцож, хуралдаанаар дор дурдсан асуудлыг хэлэлц. Үүнд:

-эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнгийн ч шинэжлэх ухааны түвшин;

-эрдэм шинжилгээний ажиглалтын ажлын үр дүн, үр чадварын ө түвшинг тогтоож, тэдний мэргэжлийг нь дэмжлүүлэх, шагнал урамшуул тодорхойлох асуудал.

ий/нэгдлийн өдөр тутмын ажлыг нэгдлийн гүйцэтгэх захирал удирдх; к/гүйцэтгэх захиралд удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн хү шинэжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүү жилийн хугацаагаар томилох бөгөөд эрхэлсэн үүргээ хангал биелүүлсэн тохиолдолд удирдах зөвлөлтэй зөвшилцөн хугацаанаас нь өтгөрүүлэх;

л/захирлыг сонгон шалгаруулахдаа эрдэм шинжилгээний ж дадлага, туршилтаг тэмцсэн байдал, бизнес, аж ахуйн үйл ажиллагаа з мэдлэг, чадвар гэрэг шалгуурыг харгалзах;

м/захирал нь шинэжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн За газрын гишүүнтэй эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэл, аж санхүүгийн үйл ажиллагааны талаар гэрэг байгуулан ажиглах бөгөө

д захирлын хөдөлмөрийн хөлс, нөхцөл, урамшуулал, ажлын цага, эрх, үүргийг тусгах.

Төрийн өмчийн оролцоотой нэгдэл нь төлөөлөн удирдах зөвлөлтэй

Төрийн өмчийн оролцоотой нэгдлийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулагч нар хууль тогтоомжийн дагуу байгуулна.

Гөлөөлөн удирдах зөвлөл нь төрийн өмчийн оролцоотой нэгдлийн ага, дүрмийг батална.

Дөрөв. Нэгдлийн үйл ажиллагааны санхүүжилт

Нэгдлийн гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 зүйлд заасны дагуу күүднэ.

Тав. Нэгдлийг татан буулгах, өөрчлөн байгуулах

Төрийн өмчийн нэгдлийг татан буулгах, өөрчлөн байгуулах ирийг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу газар гаргах бөгөөд татан буулгах тохиолдолд түүний эзэмшилд эд хөрөнгийг худалдан борлуулж, өр авлагыг барагдуулсны эцэст өг мөнгөн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Төрийн өмчийн оролцоотой нэгдлийг татан буулгах, өөрчлөн гах асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн аны төв байгууллага, үүсгэн байгуулагч нартай хамтран холбогдох огтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр
аг 2-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар
хот

Монгол-Оросын хамтарсан "Мон-
голросцветмет" нэгдлийн талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн
өгчийг нэмэгдүүлж санхүүгийн байдлыг сайжруулах зорилгоор
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
"Монголросцветмет" нэгдлийн 1995-1997 онуудад барьж ашиглалтад
н барилда байгууламжид зарцуулсан 1,9 сая ам.долларын

хэмжээгээр нэгдлийн дүрмийн сан дахь Монголын талын хувь хөрөн нэмэгдүүлэх, эсхүл тус нэгдлээс "Зарубежсветмет" нэгдэлд төлөх өрний хэмжээгээр бууруулахаар Оросын талтай тохиролцох арга хэмжээ ая Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Батбаяр, хамт "Монголроссветмет" нэгдлийн Монголын талын оролцогч Төрийн өм хорооны дарга З.Энхболд нарт даалгасугай.

2."Монголроссветмет" нэгдлийн 1991-1994 онуудад олборлосон ш ногдох нөөц ашигласны төлбөр 321,7 сая төгрөгийн асуудлыг тухайн нутгийн баг, эмсэлэг, сургууль, илэрлэг, ясан, цагдаагийн байгуу зэрэг төсөвт байгууллагуудад нэгдлээс олгосон орон байрны цахилгааны болон халаалтын зардлын төлөгдөөгүй хэсэгтэй тэнц орон нутгийн санхүүгийн байгууллагатай нийлсэн тооцооны барь үндэслэн харилцаа суутгах замаар шийдвэрлэхийг Сангийн сайдын гүйцэтгэгч Б.Батбаярт зөвшөөрсүгэй.

3."Алт-2000" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, алт олборлолтын одон хүрсэн түвшинг бууруулахгүй байх, үйлдвэрүүдийг дагаж бий болсо бүтэц, бүрэлдэн тогтсон хамт олон, мэргэжилтэй ажилчдын чалда бүрэн ашиглах зорилгоор алтны нөөц өсгөх ирээдүй бүхий та илэрхийг зохих хууль тогтоомжийг үндэслэн "Монголроссветмет" нэ олгож, туслалцаа үзүүлж ажиллахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сэ үүрэг гүйцэтгэгч Н.Алтанхуягт даалгасугай.

4."Монголроссветмет" нэгдлээс бүс нутгийг хөгжүүлэх, уурхайчды тосгоны хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шинээр ажлын бай болгох, төмс, хүнсний ногоо тариалах, газар тариалан, мал аж ахуй т талаар хийж байгаа ажлыг дэмжиж хамтран ажиллахыг холбо аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн
сайдын үүрэг гүйцэтгэгч

Н.АЛТАНХУЯГ

Сангийн сайдын үүрэг
гүйцэтгэгч

Б.БАТБАЯР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

98 оны 9 дүгээр
рын 2-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар
хот

**Алт цэвэршүүлэх үйлдвэр
байгуулах тухай**

сгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор
эл Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

бодөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Алтанхуяг,
ийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Батбаяр, Байгаль орчны сайдын үүрэг
гэгч С.Баярцогт нэрт даалгах нь:

а/жилд 10-аас доошгүй тонн алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах
ийн нөхцөлийг боловсруулан зарлаж, дүгнэсүгэй;

б/алт цэвэршүүлэх үйлдвэрийг 1999-2000 онд багтаан барьж
/лах арга хэмжээ авсугай.

Алт цэвэршүүлэх хамтарсан үйлдвэрийг байгуулахад Монголын
: оролцох хувь хэмжээ, шаардагдах хөрөнгийг тендерийг дүгнэсний
хэлбэлгэх тооцоо, судалгааг үндэслэн Засгийн газарт оруулан
эргүүлэхийг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Батбаярт
йсугай.

ингол Улсын Ерөнхий сайдын
ог гүйцэтгэгч

ЦЭЛБЭГДОРЖ

дөө аж ахуй, үйлдвэрийн
ийн сайдын үүрэг гүйцэтгэгч

Н.АЛТАНХУЯГ

нгийн сайдын үүрэг
гэгч

Б.БАТБАЯР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

98 оны 9 дүгээр
ын 2-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар
хот

**Зохион байгуулалтын бүтцийн
өөрчлөлтийн тухай**

ингол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүдөр дурдсанаар баталсугай:

а/Танхимын үйл ажиллагааг дэвших газар;

б/Стратегийн удирдлагын газар;

в/Төрийн захиргааны удирдлагын газар.

2. "Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгуулах т Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогт 2 дугаар зүйлийн "дэд дарга 1" гэсний "тэргүүн дэд дарга, дэд дарга т нэг" гэж өөрчлөн найруулсугай.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стр зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд : тогтоолын 1 дүгээр заалтаар баталсан бүтцийг нийцүүлэн ажил Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Т.Лхагваад үүрэг болгосуг

4. Энэ тогтоол гарсантай холбогдуудан "Тогтоолд өөрчлөлт о тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 295 ; тогтоол, "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стр зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрс газрын бүтцийг батлах тухай" 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрий дугаар тогтоолын 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсуг

Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ц.ЭЛБЭГДОРЖ

Хууль зүйн сайдын
үүрэг гүйцэтгэгч

С.БАТЧУЛУУ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Ганбат
Гишүүд:	С. Баяр С. Батмөнх Ч. Дашням М. Төрбаяр Б. Энэбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжинлхам

Тайх №: 65

Үндэснэрт өгөгджүүлсэн 1998 оны 9-р сарын 9-нд,
Орхотол 1998 оны 9-р сарын 30-нд, Хэвлэлтэд
1998 оны 10-р сарын 26-нд, Хэвлэлийн хуудас 6,25
Хэвлэсэн тоо 3571ш

Манай хэрг: Улаанбаатар-12

Хэргийн ордон, Утас 322858

Гэр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйн
Эрхлэх Газрын харьяа
Хэргэх үйлдвэр